



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.11.13 № 05/3270
танай 2018.11.05 ны № 01/3696

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Татварын ерөнхий газрын Мэдээлэл технологийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ганбатын Алтаншагай, Сургалтын төвийн багш, татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Галсанжавын Батсайхан нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж, уг хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гарган ажиллах нь зүйтэй.

Мөн Мэдээлэл технологийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ганбатын Алтаншагай нь ажлын байрны тодорхойлолтын тавигдах шаардлагад заасан туршлагын шалгуурыг хангаагүй байх тул заасан шаардлагад нийцсэн этгээдийг нэр дэвшүүлэн томилоход анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Х.ХАШБААТАР



0015712